

**ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН  
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 07 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын хороо 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч шинэ вакцины хөгжүүлэлт, хүн амын өвчлөлийн нөхцөл байдалтай уялдуулан А вируст гепатит, пневмококк, хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг заавал хийх дархлаажуулалтад хамрагдах сэргийлэх тарилгын нэр төрөлд оруулснаар умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, халдварт өвчний тохиолдол, нас баралтыг бууруулна гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй бөгөөд А вируст гепатитын халдварын эсрэг вакцины дархлаажуулалт болон пневмококкийн эсрэг вакциныг хийснээр уг өвчнөөр өвчлөх, нас барах бага насны хүүхдийн тоо буурч гэр бүл, эмнэлэг, улс орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг нэвтрүүлснээр папиллома вирусийн халдварын улмаас үүсэх умайн хүзүүний хорт хавдрын урьдал эмгэг, умайн хүзүүний хорт хавдар болон бэлэг эрхтний хавдрын өвчлөл, нас баралтын тоо буурах үр дүн гарна гэж төсөл санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа дархлаажуулалтын талаарх мэдээлэл дутмаг байдгаас иргэдийн хамрагдалт бага байдаг тул мэдээллийг хэрхэн хүртээмжтэй болгох талаар, умайн хүзүүний хавдар үүсгэгчээс урьдчилан сэргийлэх вакцинд эмэгтэйчүүдээс гадна гол вирус тээгч эрэгтэйчүүдийг хамруулж болох эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен хэдэн төрлийн вакцинд хэр хэмжээний төсөв зарцуулж байгаа талаар болон агаар дуслын замаар халдварын дэгдэлт нь ихсэж байгаа салхин цэцэг, корь зэрэг өвчний дархлааны талаарх патогенезийн судалгаа байгаа эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хүний хөхөнцөр вирусын дархлаажуулалтын вакциныг яаралтай товлोलт вакцин болгосноор олон хүний амь нас, эрүүл мэндийг аврах боломжтой, төрөөс иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалахад урьдчилан сэргийлэх үзлэгт оруулахаас

гадна дархлаажуулалтад хамруулах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар санал хэллээ.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 88.9 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**П.АНУЖИН**